



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2025 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Цахим систем нэвтрүүлэх зохион  
байгуулалтын арга хэмжээний тухай

Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, "Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 4.1.4-ийн 5 дахь заалтад "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож, нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно" гэснийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системийг нэвтрүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
- 2.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим системийг нэвтрүүлэх ажлын төлөвлөгөөг дагаж мөрдөх, төлөвлөсөн хугацаанд багтаан нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэлтсийн дарга, Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга, орон нутгийн өмчийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
- 3.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим системийн шилжилтийн программд 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жилийн байдлаарх хөрөнгийн бүртгэл, хөдөлгөөн, санхүүгийн тайлан мэдээг 4 дүгээр сарын 30-ны дотор үнэн зөв, бүрэн оруулахыг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга нарт даалгасугай.
- 4.Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэл, үр дүнг тооцож ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболдод даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132003071

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2025 оны 01 дугаар сарын 22-ний өдрийн  
А/02 дугаар тушаалын хавсралт



**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ШИНЭ ЦАХИМ СИСТЕМ  
НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах этгээд
2025 оны 1 сарын 13-аас 4 сарын 20 хүртэлх хугацаанд Шилжилтийн системийг ашиглан суурь мэдээллийн санг бүрдүүлэх, Төрийн болон Орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим системд шилжих бэлтгэл ажлыг хангах			
1	Орхон аймгийн ОНӨГазрынхантай уулзалт хийх / Системийн нэвтрүүлэлт Орхон аймгаас эхэлнэ/	1 дүгээр сарын 23,24	ТӨБЗГ, Орхон аймгийн ОНӨГ, Программын компани
2	Шилжилтийн системийг ашиглах видео гарын авлага бэлтгэх	1-р сарын 31-ний өдрөөс өмнө	Программын компани, ТӨБЗГ
3	Шилжилтийн системийг ашиглах сургалтыг Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээдэд зохион байгуулах	2-р сарын 7-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
4	Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээдүүд хөрөнгийн хөдөлгөөний мэдээллээ шилжилтийн системд оруулж эхлэх	1-р сарын 31-ний өдрөөс 4-р сарын 20-ны өдрийг хүртэл	ТӨБЗГ, ОНӨГ, Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
5	Нийслэл 21 аймгийн орон нутгийн өмчийн газрынхантай Улаанбаатар хотод шилжилтийн болон шинэ системийн танилцуулга уулзалт зохион байгуулах	2 дугаар сарын 10,11	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
6	Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын нэгдсэн шинэ системийн ажлын даалгаврын дэлгэрэнгүй хүснэгтийн дагуу программын хөгжүүлэлтэд хяналт тавьж ажиллах	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Программын компани
7	Төрийн болон Орон нутгийн өмчит бүх хуулийн этгээдийн дэлгэрэнгүй бүртгэлийг нягталж Улсын бүртгэлийн ерөнхий газар, Сангийн яамтай тулгах	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ
8	Барилга, байгууламжийн бүртгэлийг барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн бүртгэл гэж 3 салгах, мэдээллийг бүрэн оруулах нягтлах	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
9	Газрын бүртгэлийг E-Gazar цахим системтэй тулгах мэдээллийг бүрэн оруулах нэгж талбарын дугаарыг нягтлах	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Төрийн болон орон нутгийн өмчит

			(оролцоотой) бүх хуулийн этгээд
10	Тээврийн хэрэгслийн бүртгэлийг VRS-Transdep цахим системтэй тулгах мэдээллийг бүрэн оруулах Улсын дугаар, Арлын дугаарыг нягтлах	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
11	Машин тоног төхөөрөмжийн бүртгэлийг МТТ (үйлдвэрлэл, тусгай зориулалтын тоног төхөөрөмж), Оффисын жижиг тоног төхөөрөмж (компьютер түүний дагалдах хэрэгсэл) Батлан хамгаалах зориулалттай тоног төхөөрөмж гэж 3 салгах, мэдээллийг бүрэн оруулах нягтлах, багцалж нэг бүртгэсэн бүртгэл байвал задалж бүртгэх	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
12	Тавилга, эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн бүртгэлээс Номын фондыг салгах, мэдээллийг бүрэн оруулах нягтлах, багцалж нэг бүртгэсэн бүртгэл байвал задалж бүртгэх	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
13	Бүх биет үндсэн хөрөнгийн бодит 3 хүртэлх зураг оруулах, биет бус хөрөнгийн лиценз, гэрээ, гэрчилгээ, программын цонхны зураг зэргийг оруулах (одоогийн байдлаарх)	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
14	Төрийн болон Орон нутгийн өмчийн цахим системээс нэгдсэн хөрөнгийн дугаарлалт үүсгэх, уг дугаарыг санхүүгийн систем болон бусад системд нэвтрүүлэх	1-р сарын 13-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд, Программын компани
15	2024 оны хөрөнгийн хөдөлгөөнийг 2025 оны 4 сарын 20-ны өдрөөс өмнө, 2025 оны хөрөнгийн хөдөлгөөнийг 6 сарын 31-ний өдрөөс өмнө цахим системд оруулсан байх	2024 оны хөрөнгийн хөдөлгөөн 4-р сарын 20-ны өдрөөс өмнө, 2025 оны хөрөнгийн хөдөлгөөн 6-р сарын 31-ний өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
16	Төрийн болон Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компанийн Хувьцаа эзэмшигчийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын удирдлагын модуль бэлэн болсон байх /Шаардлагатай мэдээлэл судалгааг бэлтгэх/	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
17	Төрийн болон Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компанийн судалгаа гаргах модулийн мэдээлэл бэлэн болсон байх 1. ТУЗ-ын гишүүдийн судалгаа 2. Гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтны судалгаа	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани

	<p>3. Хуулийн этгээдээс тухай бүрд нь динамик байдлаар авах судалгаа</p> <p>4. Хуулийн этгээдийн хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгаа</p> <p>5. Хэрэглэгчийн санал асуулга</p>		
18	Төрийн болон Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагын сонгон шалгаруулалт, нөөц бүрдүүлэх модулийн мэдээлэл, шалгуур үзүүлэлт, холбогдох мэдээлэл бэлэн болсон байх.	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
19	Төрийн болон Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, түүний гишүүд болон Гүйцэтгэх удирдлагын тайлан, үнэлгээ, цалингийн модулийн мэдээлэл боловсруулж, системд оруулах холбогдох мэдээлэл бэлэн болсон байх.	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
20	Төрийн болон Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалт, шалгалтын модулийн мэдээлэл, асуулга, сургалтын материал, мэдээлэл бэлэн болсон байх. /А. Компанийн засаглалын сургалт, шалгалт, Б. Санхүү, эдийн засгийн төлөвлөлт, түүнд дүн шинжилгээ хийх В. ТӨБЗГ болон бусад байгууллагаас зарласан сургалтууд давхар цахимаар үзэх боломжтой байх/	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
21	Төрийн болон Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг тайлагнах модулийн мэдээлэл бэлэн болсон байх.	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
22	Төрийн болон Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Зорилтын саналын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг дүгнэх модулийн мэдээлэл бэлэн болсон байх. Зорилтот түвшин, Хөрөнгө оруулалт, аудитлагдсан санхүүгийн тайлангаас автоматаар таталт хийн дүгнэдэг байх	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
23	Төрийн болон Орон нутгийн өмчит Хуулийн этгээдийн жил бүрийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг төлөвлөх, түүний хэрэгжилтийг дүгнэх модулийн мэдээлэл бэлэн болсон байх	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
24	Төрийн болон Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн жил бүрийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, түүний хэрэгжилтийг дүгнэх модулийн шалгуур үзүүлэлт мэдээлэл бэлэн болсон байх	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
25	Төрийн болон орон нутгийн өмчит бүх хуулийн этгээдийн санхүүгийн тайлан, түүний тодруулга тайланг /аудитаар баталгаажсан/ автоматаар татаж системд оруулсан байх. Санхүүгийн тайлангаас гадна хуулийн этгээдээс нэмэлтээр оруулах шаардлагатай бусад санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдийг системээр илгээх боломжтой болсон байх	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
26	Төрийн болон Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдийг нэгтгэн дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийх модулийн мэдээлэл бэлэн болсон байх. Зорилтын санал, Зорилтот түвшин, Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, Санхүүгийн тайлангаас автоматаар таталт хийн, шинжилгээ хийдэг болсон байх.	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
27	Төрийн болон Орон нутгийн өмчит Хуулийн этгээдтэй холбоотой санхүү, эдийн засгийн болон үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл бүхий цахим, динамик товхимлын мэдээлэл бэлэн болсон байх.	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани

28	Төрийн болон Орон нутгийн өмчит Хуулийн этгээдийн шинэчлэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг дүгнэх, үр дүнг нийтлэх модулийн холбогдох мэдээлэл бэлэн болсон байх	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
29	Төрийн болон Орон нутгийн өмчит Хуулийн этгээдийн хувьчлал, өөрчлөн зохион байгуулалт болон орон сууц хувьчлалтай холбоотой архивын мэдээллийн сан үүсгэхэд бэлэн байх.	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
30	Төрийн болон Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Файлын сангийн мэдээлэл үүсгэхэд бэлэн болсон байх. Үүнд: А. Хуулийн этгээдийн бүртгэл, үйл ажиллагаатай холбоотой баримт бичгүүд Б. Хуулийн этгээдтэй холбоотой эрх бүхий дээд шатны байгууллага буюу УИХ, Засгийн газар, ИТХ, Засаг даргын шийдвэрүүд В. Хувьцаа эзэмшигчийн хурлын тогтоол, тэмдэглэлийн сан Г. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, тэмдэглэлийн сан Д. Аудитлагдсан санхүүгийн тайлан болон хууль журамд заасан нийтэд мэдээлбэл зохих бүх төрлийн мэдээллийн сан.	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
31	Төрийн болон Орон нутгийн өмчит Хуулийн этгээдийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг нэгтгэн удирдлага, зохицуулалтаар хангах зориулалт бүхий нэгдсэн дотоод удирдлагын панелийг үүсгэхэд шаардлагатай мэдээллийг бэлэн болсон байх.	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
32	ТӨБЗГ-ийн нэгдсэн портал вэб хуудсанд хуулийн этгээдтэй холбоотой хууль, журамд заасан санхүүгийн болон санхүүгийн бус бүх мэдээллийг нийтэд ил тод байдлаар мэдээлэх боломжоор бүрэн хангасан байх	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
33	Эрх бүхий байгууллагуудын систем, программтай холбогдоход ямар ямар мэдээлэл солилцох, ашиглах, татаж болохыг тодорхой болгох. /Жишээ нь tof.gov.mn – санхүүгийн 4 тайлан, тодруулга, улсын төсвийн хөрөнгө оруулалтын мэдээлэл, мөн худалдан авах ажиллагааны тайлан Tender.gov.mn – худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тодотгол хийсэн төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны тайлан Улсын бүртгэл – хуулийн этгээдийн удирдлагын мэдээлэл түүний өөрчлөлт, үйл ажиллагааны чиглэл түүний өөрчлөлт гэх мэт ажлыг эцсийн байдлаар тулгах, тодорхой болгох, ярилцах.	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
34	Хяналт шалгалтын төлөвлөгөө, хуваарь, удирдамж боловсруулах, шалгалтад хамрагдаж буй хуулийн этгээдэд удирдамж, тайлан хүргүүлэх явцын модуль бэлэн болсон байх, хамтран нягтлан шалгах /төлөвлөгөө, хуваарь, удирдамжийн загварыг программд хөрвүүлэх/	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
35	Цахим архив үүсгэх модуль бэлэн болсон байх	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
36	Хяналт шалгалтын төлөвлөгөө гүйцэтгэл, илэрсэн зөрчил дутагдал /хуулиар болон мөнгөн дүнгээр/, хяналт шалгалтын төрлөөр хянах самбарыг бий болгох нэгдсэн мэдээллийг үзүүлэх панель бэлэн болсон байх, хамтран нягтлан шалгах	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
37	Гүйцэтгэлийн хяналт шалгалтын загварыг программд хөрвүүлэх, хамтран нягтлан шалгах	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
38	Хууль, шүүхийн байгууллагад хянагдаж байгаа хэрэг маргааны мэдээллийг нэг бүрчлэн маргааны төрөл,	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани

	хэргийн харьяалал тус бүрээр нь задлан цахим системд оруулсан байх		
<b>2025 оны 4 сарын 20 -оос 6 сарын 1 хүртэл хугацаанд 1 аймаг, 1 яам, 1 орон нутгийн өмчит компани, 1 төрийн өмчит компани дээр туршилт хийх.</b>			
39	Орхон аймгийн төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, аж ахуйн нэгжид систем нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Орхон аймгийн ОНӨГ, Программын компани
40	Орхон аймгийн ОНӨГазрын хяналт шалгалтын төлөвлөгөө, хуваарь, удирдамж зэргийг нэвтрүүлэх бэлтгэх ажлыг хангах, хяналт шалгалт хариуцсан албан хаагч нарт программд ажиллах эрх үүргийг тодорхой болгох	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Орхон аймгийн ОНӨГ, Программын компани
41	Орхон аймгийн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд программаар дамжуулан хяналт шалгалтын төлөвлөгөө, удирдамж, тайлан хүргүүлэх талаар видео хичээл бэлтгэх	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Орхон аймгийн ОНӨГ, Программын компани
42	Эрчим хүчний яам, Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа байгууллага, төрийн өмчит компанид нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ
43	Урьдчилсан нэвтрүүлэлтэд орох байгууллагуудын 2024, 2025 оны хөрөнгийн хөдөлгөөнийг 4 сарын 20-ний өдрөөс өмнө цахим системд оруулсан эсэхийг нягтлан шалгах	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
44	Урьдчилсан нэвтрүүлэлтэд орох 1 орон нутгийн өмчит компани, 1 төрийн өмчит компанийн туршилтад шаардлагатай сүүлийн 10 жилийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг 4 сарын 20-ний өдрөөс өмнө цахим системд оруулсан байх	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
45	Орхон аймгийн ОНӨГазар болон тус аймгийн орон нутгийн өмчит 1 аж ахуйн нэгжид түрүүлж систем нэвтрүүлэхэд шаардлагатай хэрэг маргааны мэдээллийг системд оруулсан байх	4-р сарын 20-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Орхон аймгийн ОНӨГ, Программын компани
46	Урьдчилсан нэвтрүүлэлтэд орох байгууллагуудад сургалт зохион байгуулах	5-р сарын 01-ны өдрөөс өмнө	Программын компани, ТӨБЗГ, Орхон аймгийн ОНӨГ
47	Систем нэвтрүүлэх туршилтын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, илэрсэн алдаа дутагдлыг засварлах	6-р сарын 01-ны өдрөөс өмнө	Программын компани, ТӨБЗГ, Орхон аймгийн ОНӨГ
<b>2025 оны 6 сарын 1 -оос 7 сарын 1 хүртэл хугацаанд Төрийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагад сургалт хийх</b>			
48	Системийн хэрэглэгчийн дүр тус бүрээр видео сургалтын материал, ном, гарын авлага бэлтгэх	6-р сарын 01-ны өдрөөс өмнө	Программын компани, ТӨБЗГ
49	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын албан хаагчдад сургалт зохион байгуулах	7-р сарын 01-ны өдрөөс өмнө	Программын компани, ТӨБЗГ
50	Нийслэл, 21 аймгийн төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад сургалт зохион байгуулах	7-р сарын 01-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ
<b>2025 оны 7 сарын 1 -ээс систем Шинээр хийгдэж байгаа системийн Back-Office, Front-Office системийг нэвтрүүлэх.</b>			
51	Төрийн болон орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд Төрийн болон Орон нутгийн өмчийн	7 сарын 1 -ний өдрөөс 9-	ТӨБЗГ, ОНӨГ, Төрийн болон

	бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим системийн дутуу мэдээллийн дүүргэлтийг хийх	9-р сарын 1-ний өдөр хүртэл	орон нутгийн өмчит (оролцоотой) бүх хуулийн этгээд
52	Нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах хяналт тавих, илэрсэн алдаа дутагдлыг засварлах	9-р сарын 01-ны өдрөөс өмнө	Программын компани, ТӨБЗГ, ОНӨГ
53	Портал веб хуудас, Мобайл аппликэйшн нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах	9-р сарын 01-ны өдрөөс өмнө	Программын компани, ТӨБЗГ, ОНӨГ
<b>2025 оны 9 сарын 1 -ээс Иргэд, Аж ахуйн нэгжид зориулсан портал систем нэвтэрч эхлэх</b>			
54	Иргэд аж ахуйн нэгжид зориулсан видео танилцуулга, сурталчилгааны материал бэлтгэх, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараах бэлтгэл ажлыг хангах	9-р сарын 01-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
55	Иргэд, аж ахуйн нэгжид зориулсан портал систем, нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах хяналт тавих илэрсэн алдаа дутагдлыг засварлах	9-р сарын 31-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
56	Төрийн болон Орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим системийн нээлтийн ажиллагаанд Ерөнхий сайдыг оролцуулан зохион байгуулах	9-р сарын 31-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, ОНӨГ, Программын компани
<b>2025 оны 9 сарын 31-нд Төрийн болон орон нутгийн өмчийн цахим системийг бүрэн хүлээж авах.</b>			
57	Оролцогч талуудын уулзалт хийж бета /эхний/ хувилбарыг танилцуулах, систем хөгжүүлэлтийг эцэслэх	9-р сарын 31-ны өдрөөс өмнө	ТӨБЗГ, Программын компани,

## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР